



“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 11-ний өдөр

Дугаар 20/03

Улаанбаатар

Г

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай

Г

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.4, 60 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн дүрмийн 3.3 дахь заалт, “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Хот Девелопмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 сарын 22-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, БиДиСЕК ҮЦК ХК-ийн төв байранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;
 - Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
 - Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсвийг батлах тухай;
 - Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах;
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг “Хурал хуралдуулах тухай зар”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 16 дахь өдөр буюу 2020 оны 03 сарын 27-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 дахь өдөр буюу 2020 оны 03 сарын 16-ны өдөр Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2020 оны 03 сарын 31 -ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комист даалгасугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-аар баталсугай. Хавсралт №3-д заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв оффист ирж танилцах боломжтой.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай.
8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2020 оны 04 сарын 22-ны өдрийн 10:00 цаг байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Д.Даянбилгүүн, хурал зохион байгуулах комиссын даргаар Х.Азбаяр, гишүүнээр Э.Эрхэмзаяа, тооллогын комиссын даргаар Б.Тэмүүлэн, гишүүнээр Б.Даваадорж нарыг тус тус томилсугай.
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Д.ДАЯНБИЛГҮҮН/